



ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын тайлан

АУДИТЫН КОД: САГ-2018/7/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон

Гэрээт ажилтан Э.Ундармаа

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	1
2.1 Оршил	1
2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5 Дотоод хяналт	3
2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7 Шилэн дансны мэдээлэл	4
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1. Санхүүгийн тайлангийн талаар.....	5
2.9.2. Төсөл сонгон шалгаруулалтын талаар.....	5
2.9.3. Авлагын талаар	6
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	8
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	9
2.15 Аудитын үр өгөөжийн талаар	9
2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	22
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	22
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	26
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	28
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	29
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	31



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 06/825
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг саналын дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323\SAG45.Docx

071500


Аудитын гол асуудал

- ЗГ-ын 2016 оны 138 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд зааснаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд олгох 35,000.0 хүртэл сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг даалгажээ. Гэвч тус сайдын 2016 оны 12 дугаар сарын А/62 дугаар тушаалын дагуу 83 иргэн, аж ахуйн нэгжид 39,615.4 сая төгрөгийг тус сангийн 2016 онд батлагдсан төсвийн эх үүсвэрээс олгосон нь дээрх Засгийн газрын тогтоолыг зөрчиж санхүүжилтийг 4,615.4 сая төгрөгөөр илүү зарцуулсан;
- Төсөл сонгон шалгаруулалтыг нэг бүрчлэн үзэхэд зарим зээлдэгч нарын зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлагыг хангаагүй, баримтын бүрдэл дутуу, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тодорхойлолтгүй, барьцаа хөрөнгө нь аль нэг этгээдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн /итгэмжлэл байхгүй/ сонгон шалгаруулсан нь “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын 4 дүгээр зүйлд заасан “Зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлага”-ыг зөрчсөн;
- Зээл болон хүүгийн, бусад тооцооны авлага зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлага тусгагдсаны 2.6 хувь буюу 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй;
- Зээлийн төлөх хугацаа нь дууссан, зээлээ төлөөгүй 2,377.6 сая төгрөгийн 22 зээлдэгчийн авлагыг барагдуулах талаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлээгүй, авлагыг барагдуулаагүй;
- Тус сан тайлант оны санхүүгийн тайланд 32 зээлдэгчийн 984.0 сая төгрөгийн зээлийн авлага, 205.0 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг тусгаагүй;
- Анхан шатны баримтын бүрдэлгүй, юуны авлага болох нь тодорхойгүй нийт 118.1 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

СОНГОЛ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирал С.Төгсбилэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, төсвийн гүйцэтгэл, зардал, зээл олголт, зээлийн эргэн төлөлт, хууль эрх зүйг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж шалгалт алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 5-наас 2018 оны 3 дугаар сарын 24-ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт ажилтан Э.Ундармаа нар хэрэгжүүлэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын баг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 27-нд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захиралд гардуулна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлнэ гэж тодорхойлжээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурьдсан зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:


- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж урт хугацааны, хөнгөлөлттэй зээл олгох,
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн түрээс /лизинг/-ээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглахад дэмжлэг үзүүлэх,
- Төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах,
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх,
- Зээлийн давхар батлан даалтын үйлчилгээ үзүүлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д “Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн” гэж заасны дагуу тус сангийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, Үйлдвэрийг дэмжих тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Тайлант онд МУ-ын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.13-т “Хүнс, бодлогын асуудал, дотоод худалдаа, үйлчилгээний бодлого, зохихуулалтын асуудлын хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага зохицуулалт болон дүн



шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ” гэсэн заалтын дагуу Аж үйлдвэрийн яам татан буугдсанаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хамаарах болсон байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын “Журам батлах тухай” 2006 оны 388 дугаар тушаалын дагуу гаргахдаа тодруулга, мэдээллийг бэлтгээгүй байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд тусгасан 421 харилцагчийн тооцоо нийлсэн актыг өглөг, авлагын журнал болон зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай тулган баталгаажуулалт хийж, төсөл сонгон шалгаруулалтын зөрчлийг нэгтгэн гаргалаа.


Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хэрэгжүүлсэн горим сорилын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын “Acolous” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.



Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт их гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, мөн ЗГ-ын 2015 оны 483 дугаар тушаалаар баталсан Дотоод аудитын дүрмийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 11 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын хуралдаанаар Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас олгосон зээлийн эргэн төлөлтөд шалгалт хийж, чанар, гүйцэтгэлийн талаарх дүнг танилцуулахыг ХХААХҮ-ийн сайд асан П.Сэргэлэнд даалгасны дагуу тус сайдын 2016 оны 11 дүгээр сарын А-122 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж Хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банкнаас арилжааны банкаар дамжуулан олгосон зээлийн хүрээнд хэрэгжиж буй төслийн хэрэгжилт, явц байдалд хяналт шалгалт хийсэн байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.


Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 дугаар сард батлагдсан хуулиар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсвийг 50,608.6 сая төгрөгөөр, дотоодын эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтийг 52,000.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Тайлант онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төсвийг 38.2 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулж, үндсэн үйл ажиллагааны орлогоор 30,714.0 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 19,846.0 сая төгрөгийн орлогыг тус тус олсон байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоонд хангах хүрээнд тус сан өөрийн цахим хуудсаар <http://mofa.gov.mn> байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар анхаарч үзлээ. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд шилэн дансны цахим



хуудсанд 2017 онд орлогын 246,591.9 сая төгрөгийн 494 мэдээлэл, зарлагын 123,365.2 сая төгрөгийн 232 мэдээлэл байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1. Санхүүгийн тайлангийн талаар

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 2017 оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулга бэлтгэж ирүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмын 3 дугаар зүйлийн 3.1-д заасан Санхүүгийн тайлангийн бүтэц тайлангийн тэмдэглэл, тодруулгаас бүрдэнэ гэсэн заалт, аудитын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан нийт зээлийн авлагаас 2009-2016 онд 87 зээлдэгчид олгосон 19,732.6 сая төгрөгийн зээлийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлж тайлант хугацаанд тус санд 187.3 сая төгрөгийг эргэн төвлөрүүлсэн байна. Гэтэл 2017 оны 5 дугаар сарын 25-ний өдрийн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санал болгох хуралдаанаар шийдвэрлэсэн төлбөрт шилжүүлэн өгөх саналын дагуу “Эн Ви Си” ХХК-наас хураагдсан 601.0 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгүүдийг зээлийн авлагад тооцож олгохоор шийдвэрлэснийг хүлээн авч, хөрөнгийг тус сан эргэлтийн хөрөнгөнд бүртгээгүй байна. Энэ нь аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх 601.0 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх талаар зөвлөмж өгөх.

2.9.2. Төсөл сонгон шалгаруулалтын талаар

1.3Г-ын 2016 оны 138 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд зааснаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд олгох 35,000.0 хүртэл сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг даалгажээ. Гэвч тус сайдын 2016 оны 12 дугаар сарын А/62 дугаар тушаалын дагуу 83 иргэн, аж ахуйн нэгжид 39,615.4 сая төгрөгийг тус сангийн 2016 онд батлагдсан төсвийн эх үүсвэрээс олгосон нь дээрх Засгийн газрын тогтоолыг зөрчиж санхүүжилтийг 4,615.4 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн



заалт, аудитын “Тохиолдсон байх”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-ийг баримтлан ажиллаж, батлагдсан төсөв болон эрх зүйн актын хүрээнд зээл олгож байх талаар зөвлөмж өгөх.

2.Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын дагуу төсөл сонгон шалгаруулах хорооны 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны шийдвэрээр нийт 212 төслийг шалгаруулжээ.

Дээрх төсөл сонгон шалгаруулалтыг нэг бүрчлэн үзэхэд зарим зээлдэгч нарын зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлагыг хангаагүй, баримтын бүрдэл дутуу, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тодорхойлолтгүй, барьцаа хөрөнгө нь аль нэг этгээдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн /итгэмжлэл байхгүй/ сонгон шалгаруулсан нь “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын 4 дүгээр зүйлд заасан “Зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлага”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах эрх зүйн актыг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөх.

3.ЖДҮХС-гийн захирлын 2016 оны 12 дугаар сарын А/18 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх “Үнэлгээний аргачлал”-ыг баталсан байна.

Тус “Үнэлгээний аргачлал” нь ямар эрх зүйн актыг үндэслэсэн нь тодорхойгүй, зарим зээлдэгч нарын барьцааны гэрээнд уг аргачлалаар тодорхойлоогүй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан, зээлийн дүнгээс доогуур хөрөнгө барьцаалсан, улсын бүртгэлийн ерөнхий газраар баталгаажуулаагүй зарим хөрөнгийн барьцааны гэрээ байхгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.


Шийдвэрлэсэн нь: Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг үндэслэн барьцаа хөрөнгийг үнэлэх үнэлгээний аргачлал шинэчлэн боловсруулах талаар зөвлөмж өгөх.

4.“Их модун” ХХК-д 2013 онд 620.0 сая төгрөгийн зээлийг олгосон боловч тус компани зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлээ төлөөгүй байхад 2014 онд 385.0 сая төгрөгийн зээлийг дахин олгосноос тухайн компанийн зээл найдваргүйд тооцогдож хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны 6 дугаар сарын А/76 дугаар тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.1-д заасан “Санд төлөх муу зээлийн үлдэгдэлтэй бол хөнгөлөлттэй зээлд хамрагдахгүй” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.9.3. Авлагын талаар

1.ЖДҮХС-гийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл зэрэг нийт 274,025.7 сая



төгрөгийн авлага тусгагдсаны 2.6 хувь буюу 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй байна. Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6-г тус тус баримтлан ажиллаж дээрх тооцоо нийлээгүй зээл болон зээлийн хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг баталгаажуулах талаар зөвлөмж өгөх.

2. 2013 оноос хойш олгосон 330 зээлдэгчийн гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 2017 онд төлөх 54 зээлдэгчийн 1,441.2 сая төгрөгийн үндсэн зээл, 135 зээлдэгчийн 343.5 сая төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдөөгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-ыг баримтлан ажиллаж, 2017 онд төлөх 54 зээлдэгчийн 1,441.2 сая төгрөгийн үндсэн зээл, 135 зээлдэгчдийн 343.5 сая төгрөгийн зээлийн хүүг нөхөн төлүүлэх талаар албан шаардлага өгөх.


3. Зээл болон зээлийн хүүгийн, бусад тооцооны авлага зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлагын 7.4 хувь буюу 20,273.9 сая төгрөгийн авлага шүүхээр шийдвэрлэгдэж байгаа боловч зээлийн төлөх хугацаа нь дууссан, зээлээ төлөөгүй 2,377.6 сая төгрөгийн 22 зээлдэгчийн авлагыг барагдуулах талаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлээгүй, авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-ыг баримтлан ажиллаж, дээрх 2,377.6 сая төгрөгийн тооцоо нийлээгүй зээл болон хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар зөвлөмж өгөх.

4. Зээл төлөгдөөгүй байтал “Их буянт цагаан эсгий” хоршоо болон иргэн Д.Одэрдэнэ нарын 7.2 сая төгрөгийн зээлийн авлагыг барагдуулснаар санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Энэ нь аудитын “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г баримтлан ажиллаж дээрх 7.2 сая төгрөгийг эзэн холбогдогч нарт зээлийн авлагын дүнд нэмж тусгах талаар албан шаардлага өгөх.

5. Анхан шатны баримтын бүрдэлгүй, юуны авлага болох нь тодорхойгүй нийт 118.1 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г баримтлан ажиллаж дээрх 118.1 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тодорхойлж, шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх.

6.Тус сан тайлант оны санхүүгийн тайланд 56 зээлдэгчийн 1,181.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн авлагыг тусгаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.№

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-г баримтлан ажиллаж дээрх авлагыг санхүүгийн тайланд тусгах талаар албан шаардлага өгөх.

7.ЖДҮХС-гийн 2017 оны санхүүгийн тайланд тусгасан нийт 667.6 сая төгрөгийн зээлийн авлагын хүүг зээл олгох гэрээ байгуулсан өдрөөс эхлэн зээл төлөгдөх нийт хугацаагаар буюу 5 жилийн хүүгийн авлагыг тооцож бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна. Энэ нь аудитын “Хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-ийг баримтлан ажиллаж, зээлийн хүүгийн авлагыг тухайн онд хамаарах хүүг тооцож бүртгэх талаар зөвлөмж өгөх.

8.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн нэгдсэн програм байхгүй “excel” програмаар тооцооллыг гүйцэтгэж байгаа нь зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн нэгдсэн програм авах талаар зөвлөмж өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ


ЖДҮХС-ийн холбогдох албан тушаалтнууд зээлийн эргэн төлөлт болон хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах, зээлийн эргэн төлөлтийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, зээлийн нэгдсэн програм байхгүй, “excel” програмаар зээлийн тооцоог бүртгэж байгаа нь зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийг үүсгэж байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй асуудал нь Арилжааны банкаар олгож байгаа ЖДҮХС-гийн зээлийг зээлдэгч тус бүрээр хянах боломжгүй байлаа.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 18,762.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 2,973.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 15,789.0 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өглөө.



2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2016 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 7 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,112.9 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 42.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Аудитын үр өгөөжийн талаар

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах аудитаар нийт 16,000.1 сая төгрөгийн санхүүгийн, 2,762.6 сая төгрөгийн санхүүгийн бус нийт 18,762.7 сая төгрөгийн үр өгөөж бий болсныг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн тул үр өгөөжийн бүртгэл /Маягт УАГ 1120/-д бүртгэсэн болно.

2.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын сөрөг санал дүгнэлт өгөх үндэслэлтэй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Санхүүгийн тайлангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан 2017 оны санхүүгийн тайлангийн тэмдэглэл, тодруулга бэлтгэж ирүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмын 3 дугаар зүйлийн 3.1-д заасан Санхүүгийн тайлангийн бүтэц тайлангийн тэмдэглэл, тодруулгаас бүрдэнэ гэсэн заалт, аудитын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан журмыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2 Санхүүгийн тайлангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан нийт зээлийн авлагаас 2009-2016 онд 87 зээлдэгчид олгосон 19,732.6 сая төгрөгийн зээлийн авлагыг шүүхээр шийдвэрлүүлж тайлант хугацаанд тус санд 187.3 сая төгрөгийг эргэн төвлөрүүлсэн байна. Гэтэл 2017 оны 5 дугаар сарын 25-ний өдрийн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санал болгох хуралдаанаар шийдвэрлэсэн төлбөрт шилжүүлэн өгөх саналын дагуу “Эн Ви Си” ХХК-наас хураагдсан 601.0 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгүүдийг зээлийн авлагад тооцож олгохоор шийдвэрлэснийг хүлээн авч, хөрөнгийг тус сан эргэлтийн хөрөнгөнд бүртгээгүй байна. Энэ нь аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

601.0 сая төгрөгийн хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Оршин байх – Санхүүгийн тайлангийн дуусгавар болгосон өдөр хөрөнгө /авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 Төсөл сонгон шалгаруулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

ЗГ-ын 2016 оны 138 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд зааснаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2016 онд олгох 35,000.0 хүртэл сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг даалгажээ. Гэвч тус сайдын 2016 оны 12 дугаар сарын А/62 дугаар тушаалын дагуу 83 иргэн, аж ахуйн нэгжид 39,615.4 сая төгрөгийг тус сангийн 2016 онд батлагдсан төсвийн эх үүсвэрээс олгосон нь дээрх Засгийн газрын тогтоолыг зөрчиж санхүүжилтийг 4,615.4 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт, аудитын “Тохиолдсон байх”, “Толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-ийг баримтлан ажиллаж, батлагдсан төсөв болон эрх зүйн актын хүрээнд зээл олгож байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Тохиолдсон байх – Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх.

Толилуулга ба тодруулга – Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Төсөл сонгон шалгаруулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын дагуу төсөл сонгон шалгаруулах хорооны 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хуралдааны шийдвэрээр нийт 212 төслийг шалгаруулжээ.

Дээрх төсөл сонгон шалгаруулалтыг нэг бүрчлэн үзэхэд зарим зээлдэгч нарын зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлагыг хангаагүй, баримтын бүрдэл дутуу, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгүүлсэн тухай тодорхойлолтгүй, барьцаа хөрөнгө нь аль нэг этгээдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг үндэслэн /итгэмжлэл байхгүй/ сонгон шалгаруулсан нь “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын 4 дүгээр зүйлд заасан “Зээл хүсэгчийн төсөлд тавигдах шаардлага”-ыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах эрх зүйн актыг баримтлан ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.5 Төсөл сонгон шалгаруулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

ЖДҮХС-гийн захирал 2016 оны 12 дугаар сарын А/18 дугаар тушаалаар хөнгөлөлттэй зээлд хамрагдах иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх “Үнэлгээний аргачлал”-ыг баталсан байна.

Тус “Үнэлгээний аргачлал” нь ямар эрх зүйн актыг үндэслэсэн нь тодорхойгүй, зарим зээлдэгч нарын барьцааны гэрээнд уг аргачлалаар тодорхойлоогүй үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан, зээлийн дүнгээс доогуур хөрөнгө барьцаалсан, улсын бүртгэлийн ерөнхий газраар баталгаажуулаагүй зарим хөрөнгийн барьцааны гэрээ байхгүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

ҮАГ-ын зөвлөмж

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийг үндэслэн барьцаа хөрөнгийг үнэлэх үнэлгээний аргачлал шинэчлэн боловсруулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.6 Төсөл сонгон шалгаруулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

“Их модун” ХХК-д 2013 онд 620.0 сая төгрөгийн зээлийг олгосон боловч тус компани зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлээ төлөөгүй байхад 2014 онд 385.0 сая төгрөгийн зээлийг дахин олгосноос тухайн компанийн зээл найдваргүйд тооцогдож хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэж байна.

ҮАГ-ын зөвлөмж

2017 оны 6 дугаар сарын А/76 дугаар тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.1-д заасан “Санд төлөх муу зээлийн үлдэгдэлтэй бол хөнгөлөлттэй зээлд хамрагдахгүй” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.7 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

ЖДҮХС-гийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор 2009 оноос хойш олгосон Арилжааны банкнаас авах зээлийн авлага, Ахуй үйлчилгээний төв болон бөөний худалдааны зээл, Оёдлын үйлдвэрүүдийн нэгдсэн холбоо, Сүү төслийн болон Түүхий эдийн төв байгуулах, Хөдөлмөрийн сайд /хуучнаар/, Хүнс, хөдөө аж ахуйн сайд /хуучнаар/-уудын тушаалуудаар олгосон зээл, бусад тооцооны авлага зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлага тусгагдсаны 2.6 хувь буюу 7,024.3 сая төгрөгийн авлага болон зээлийн хүүгийн үлдэгдэлд тооцоо нийлээгүй байна.

Энэ нь Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, аудитын “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Оршин байх – Санхүүгийн тайлангийн дуусгавар болгосон өдөр хөрөнгө /авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6-г тус тус баримтлан ажиллаж дээрх тооцоо нийлээгүй зээл болон зээлийн хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг баталгаажуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.8 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Зээл болон зээлийн хүүгийн, бусад тооцооны авлага зэрэг нийт 274,025.7 сая төгрөгийн авлагын 7.4 хувь буюу 20,273.9 сая төгрөгийн авлага шүүхээр шийдвэрлэгдэж байгаа боловч зээлийн төлөх хугацаа нь дууссан, зээлээ төлөөгүй 2,377.6 сая төгрөгийн 22 зээлдэгчийн авлагыг барагдуулах талаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлээгүй, авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-ыг баримтлан ажиллаж, дээрх 2,377.6 сая төгрөгийн тооцоо нийлээгүй зээл болон хүүгийн авлага, бусад тооцооны авлагыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Эрх ба үүрэг – Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.9 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Анхан шатны баримтын бүрдэлгүй, юуны авлага болох нь тодорхойгүй нийт 118.1 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж байна. Энэ нь аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г баримтлан ажиллаж дээрх 118.1 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тодорхойлж, шийдвэрлэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Эрх ба үүрэг – Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө/авлага/ уг аж ахуйн нэгж, байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.10 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

ЖДҮХС-гийн 2017 оны санхүүгийн тайланд тусгасан нийт 667.6 сая төгрөгийн зээлийн авлагын хүүг зээл олгох гэрээ байгуулсан өдрөөс эхлэн зээл төлөгдөх нийт хугацаагаар буюу 5 жилийн хүүгийн авлагыг тооцож бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна. Энэ нь аудитын “Хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-ийг баримтлан ажиллаж, зээлийн хүүгийн авлагыг тухайн онд хамаарах хүүг тооцож бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Хэмжилт – Аж ахуйн нэгж, байгууллага ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого, зардлыг зөв хуваарилсан байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.11 Зээлийн програмын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн нэгдсэн програм байхгүй “excel” програмаар тооцооллыг гүйцэтгэж байгаа нь зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сулруулж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Зээлийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор зээлийн нэгдсэн програмтай болох.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**СӨРӨГ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	313,368,071,098.36	274,079,309,985.35
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,548,314.76	381,871.01
Кассанд байгаа бэлэн мөнгө	3,548,314.76	381,871.01
Төгрөг	579,811.00	381,871.01
Касс арилжааны банк	2,968,503.76	-
АВЛАГА	313,357,264,243.60	274,061,171,134.34
Бусад авлага	313,357,264,243.60	274,061,171,134.34
Байгууллагаас авах авлага	313,357,264,243.60	274,061,171,134.34
УРЬДЧИЛГАА	555,000.00	9,785,000.00
Урьдчилж гарсан зардал	555,000.00	9,785,000.00
БАРАА МАТЕРИАЛ	6,703,540.00	7,971,980.00
Хангамжийн материал	6,703,540.00	7,971,980.00
Бусад хангамжийн материал	6,703,540.00	7,971,980.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	233,997,073.67	155,850,776.29
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	233,997,073.67	155,850,776.29
Биет хөрөнгө	126,417,073.59	84,130,776.17
Авто-тээврийн хэрэгсэл	125,800,000.00	124,771,181.00
Хуримтлагдсан элэгдэл	(85,069,351.98)	(118,692,662.57)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	65,505,574.19	70,245,254.19
Хуримтлагдсан элэгдэл	(40,425,033.55)	(44,418,580.99)
Тавилга, аж ахуйн эд хогшил	78,946,107.20	78,946,107.20
Хуримтлагдсан элэгдэл	(18,340,222.27)	(26,720,522.66)
Биет бус хөрөнгө	107,580,000.08	71,720,000.12
Програм хангамж	181,500,000.00	181,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(73,919,999.92)	(109,779,999.88)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	313,602,068,172.03	274,235,160,761.64
НИЙТ ӨР ТӨЛБӨР	229,089,965,398.84	179,162,036,305.06
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	229,089,965,398.84	1,000.00
Өглөг	229,089,965,398.84	1,000.00
Ажилчидтай холбогдсон өглөг	161,910.02	-
Бусад өглөг	229,089,803,488.82	1,000.00
Байгууллагад төлөх өглөг	229,089,673,737.82	-
Хувь хүмүүст төлөх өглөг	129,751.00	1,000.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	179,162,035,305.06
Урт хугацаат үнэт цаас	-	130,150,734,152.00
Төгрөг	-	130,150,734,152.00
Бонд	-	130,150,734,152.00
Урт хугацаат зээл	-	49,011,301,153.06
Төгрөг	-	49,011,301,153.06
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	49,011,301,153.06
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	84,512,102,773.19	95,073,124,456.58
Засгийн газрын хувь оролцоо	84,512,102,773.19	95,073,124,456.58

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
СӨРӨД
САНАЛ ДҮГНЭЛТ

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,596,924,523.84	1,596,924,523.84
Хуримтлагдсан үр дүн	82,913,933,749.72	93,474,955,433.11
Өмнөх үеийн үр дүн	81,724,433,743.81	91,910,247,951.50
Тайлант үеийн үр дүн	1,189,500,005.91	1,564,707,481.61
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,244,499.63	1,244,499.63
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	313,602,068,172.03	274,235,160,761.64



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	/төгрөгөөр/
		ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,123,984,690.26	3,698,024,672.05
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,123,984,690.26	3,690,824,672.05
Нийтлэг татварын бус орлого	4,123,984,690.26	3,690,824,672.05
Төсөв байгууллагын өөрийн орлого	4,123,984,690.26	3,690,824,672.05
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,123,435,553.07	3,690,824,672.05
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	549,137.19	
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,200,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс		7,200,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,200,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,934,484,684.35	2,112,899,015.43
УРСГАЛ ЗАРДАЛ	2,934,484,684.35	2,112,899,015.43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	965,046,687.33	764,004,381.58
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,398,929.80	321,972,451.00
Үндсэн цалин	324,398,929.80	321,972,451.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,916,312.68	35,744,159.91
Тэтгэврийн даатгал	22,880,409.68	22,828,756.67
Тэтгэмжийн даатгал	2,617,010.00	2,979,077.81
ҮОМШӨ-ний даатгал	3,255,905.00	2,856,614.65
Ажилгүйдлийн даатгал	651,182.00	643,609.16
Эрүүл мэндийн даатгал	6,511,806.00	6,436,101.62
Хангамж, бараа материалын зардал	40,157,777.62	25,899,100.10
Бичиг хэрэг	7,271,600.02	7,991,860.00
Тээвэр, шатахуун	20,787,500.00	6,376,019.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,784,992.60	8,600,861.10
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,313,685.00	2,930,360.00
Томилолт, зочны зардал	87,032,342.00	104,298,945.00
Дотоод албан томилолт	87,032,342.00	104,298,945.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	215,621,951.00	53,422,923.20
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	214,355,821.00	46,532,253.20
Даатгалын үйлчилгээ	222,750.00	1,415,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	449,480.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,500.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,000.00	5,385,240.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	97,400.00	89,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	261,919,374.23	222,666,802.37
Бараа үйлчилгээний бусад зардал	85,191,393.00	45,147,375.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,756,700.00	115,051,625.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,971,281.23	62,467,802.37
ХҮҮ	1,869,997,997.02	1,320,767,833.85

ТӨРИЙН АУДИТ ОРГОНУУЛАГА
СЭРЭГ
САНГАЛ ДҮНДЭЛТ

Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,869,997,997.02	1,320,767,833.85
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	1,869,997,997.02	1,320,767,833.85
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,440,000.00	28,126,800.00
Бусад урсгал шилжүүлэг	99,440,000.00	28,126,800.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	62,372,900.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	37,067,100.00	28,126,800.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (Ш)=(1)-(П)	1,189,500,005.91	1,585,125,656.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	2,938,491.56
Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		2,938,491.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	23,356,666.57
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	23,356,666.57
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(in)+(IV)-(V)	1,189,500,005.91	1,564,707,481.61



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	109,185,114,392.16	103,305,221,917.01
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,562,268,175.45	103,298,021,917.01
Нийтлэг татварын бус орлого	76,562,268,175.45	103,298,021,917.01
Төсөв байгууллагын өөрийн орлого	76,554,532,598.87	63,370,383,484.25
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,848,684,169.16	43,524,375,209.64
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	35,705,848,429.71	19,846,008,274.61
Бусад орлого	7,735,576.58	39,927,638,432.76
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,622,846,216.71	7,200,000.00
Улсын төвлөрсөн төсвөөс	32,622,846,216.71	7,200,000.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		7,200,000.00
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	32,622,846,216.71	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	53,427,649,597.40	53,504,730,180.76
УРСГАЛ ЗАРДАЛ	53,427,649,597.40	53,504,730,180.76
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,787,106.08	731,359,861.53
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,398,929.80	314,881,811.41
Үндсэн цалин	271,273,072.80	260,002,011.41
Унаа хоолны хөнгөлөлт	53,125,857.00	42,705,000.00
Урамшуулал		12,174,800.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,916,312.68	34,632,460.82
Тэтгэврийн даатгал	22,880,409.68	22,246,565.51
Тэтгэмжийн даатгал	2,617,010.00	2,524,824.45
ҮОМШӨ-ний даатгал	3,255,905.00	3,081,487.59
Ажилгүйдлийн даатгал	651,182.00	615,648.68
Эрүүл мэндийн даатгал	6,511,806.00	6,163,934.59
Хангамж, бараа материалын зардал	40,372,427.60	27,374,541.10
Бичиг хэрэг	5,542,390.00	5,028,850.00
Тээвэр, шатахуун	21,812,500.00	6,913,200.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,784,992.60	8,617,361.10
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,232,545.00	6,815,130.00
Эд хогшил, урсгал засварын зардал		
Багаж, техник, хэрэгсэл		
Томилолт, зочны зардал	87,032,342.00	103,785,285.00
Дотоод албан томилолт	87,032,342.00	103,785,285.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,413,451.00	58,208,303.20
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	169,862,321.00	51,317,633.20
Даатгалын үйлчилгээ	312,750.00	1,415,830.00
Тээврийн хэрэгслийн татвар	359,480.00	
Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,500.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,743,000.00	5,385,240.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	97,400.00	80,600.00
Бараа үйлчилгээний бусад зардал	200,653,643.00	192,477,460.00